ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2023/118/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br><br>Чойбалсан хот<br>2023 он | Дорнод аймаг дахьТөрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Ари файнэнс аудит” ХХК<br>Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 219

танай ____________-ны № ______________-т

ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ В.АЛТАНСУВД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавруудын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар , хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа

011020210

тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд, холбоо барих мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **132,644,833.12** | **147,074,088.52** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **-** | **10,769,087.20** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **-** | **10,769,087.20** |
| **3121** | **Төгрөг** | **-** | **10,769,087.20** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 10,769,087.20 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **132,644,833.12** | **136,305,001.32** |
| **351** | **Түүхий эд материал** | **274,440.00** | **1,255,840.00** |
| 35130 | Эм боох материал | 274,440.00 | 1,255,840.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **132,370,393.12** | **135,049,161.32** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 411,240.00 | 178,380.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,779,191.00 | 7,108,291.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 488,800.00 | 236,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 122,691,162.12 | 127,526,490.32 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,508,483,967.20** | **1,528,905,862.95** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,508,483,967.20** | **1,528,905,862.95** |
| **392** | **Биет хөрөнгө** | **983,318,967.20** | **1,003,685,862.95** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,000,149,208.00 | 1,000,149,208.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (64,181,655.72) | (84,233,546.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 92,443,633.40 | 92,101,693.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (75,881,866.33) | (45,027,981.76) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,920,242.26 | 58,489,533.46 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,130,594.57) | (24,147,227.63) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,999,999.84) | (5,999,999.76) |
| 39217 | Ном | - | 2,354,184.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **525,165,000.00** | **525,220,000.00** |
| 39301 | Програм хангамж | 995,500.00 | 1,215,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (830,500.00) | (995,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 525,000,000.00 | 525,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,641,128,800.32** | **1,675,979,951.47** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,641,128,800.32** | **1,675,979,951.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,641,128,800.32** | **1,675,979,951.47** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,264,090,040.84 | 1,264,090,040.84 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,264,090,040.84 | 1,264,090,040.84 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (378,658,807.49) | (343,807,656.34) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (378,658,807.49) | (2,019,787,607.81) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,675,979,951.47 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 755,697,566.97 | 755,697,566.97 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,641,128,800.32** | **1,675,979,951.47** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **799,597,549.91** | **2,740,474,649.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **48,363,129.91** | **1,681,749,047.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **22,433,113.91** | **1,681,749,047.32** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **22,433,113.91** | **8,498,400.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,081,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 6,417,200.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 22,433,113.91 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 1,529,738,163.20 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 143,512,484.12 |
| 121 | Хөрөнгийн орлого | 25,930,016.00 | |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 25,930,016.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **36,387,620.00** | **1,058,725,602.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **-** | **991,741,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 991,741,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 714,846,800.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **17,328,820.00** | **5,104,302.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,328,820.00 | 5,104,302.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **19,058,800.00** | **61,880,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,058,800.00 | 61,880,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **826,987,374.97** | **1,064,494,697.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **826,987,374.97** | **1,064,494,697.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **773,988,574.40** | **984,165,232.32** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **583,897,283.00** | **770,023,347.80** |
| 210101 | Үндсэн цалин | 432,090,746.00 | 531,816,025.80 |
| 210102 | Нэмэгдэл | 102,161,104.00 | 193,775,984.00 |
| 210104 | Урамшуулал | 49,645,433.00 | 44,431,338.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **77,486,314.43** | **96,252,770.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,125,349.43 | 65,451,963.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,840,341.00 | 7,700,202.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,671,833.00 | 6,160,242.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,168,109.00 | 1,539,960.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,680,682.00 | 15,400,403.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,056,645.91** | **27,242,551.47** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,686,109.00 | 5,585,299.47 |
| 210302 | Түлш, халаалт | 10,311,636.91 | 12,802,592.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,058,900.00 | 8,854,660.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,656,546.00** | **15,750,892.80** |
| 210401 | Бичиг хэрэг | 537,831.00 | 972,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 100,000.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 565,100.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | - | 2,354,184.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 913,900.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,539,715.00 | 955,270.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 11,469,038.80 |
| 2105 | Нормативт зардал | 7,022,219.00 | |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,908,019.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,114,200.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,692,200.00** | **1,447,400.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,692,200.00 | 1,447,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,204,300.00** | **8,885,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,204,300.00 | 2,081,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 6,804,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **76,973,066.06** | **64,563,070.25** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 30,511,370.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 46,151,293.27 | 1,176,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 30,321,772.79 | 32,875,300.25 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **52,998,800.57** | **80,329,465.53** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,607,772.00** | **73,909,251.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,153,002.00 | 54,424,050.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,454,770.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 5,104,302.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 14,380,899.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 22,391,028.57 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,391,028.57 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **2,154.09** | **6,420,214.53** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,154..09 | 6,420,214.53 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(27,391,979.15)** | **1,675,979,951.47** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(27,391,979.15)** | **1,675,979,951.47** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон /төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **751,234,420.00** | **1,067,224,002.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **8,498,400.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 8,498,400.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 8,498,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,081,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 6,417,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **751,234,420.00** | **1,058,725,602.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | **991,741,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 991,741,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 714,846,800.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **17,328,820.00** | **5,104,302.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,328,820.00 | 5,104,302.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **19,058,800.00** | **61,880,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,058,800.00 | 61,880,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **751,234,420.00** | **1,024,411,914.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **751,234,420.00** | **1,024,411,914.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **698,233,465.34** | **944,082,449.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **584,029,055.00** | **770,023,347.80** |
| 210101 | Үндсэн цалин | 432,222,518.00 | 531,816,025.80 |
| 210102 | Нэмэгдэл | 102,161,104.00 | 193,775,984.00 |
| 210104 | Урамшуулал | 49,645,433.00 | 44,431,338.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **77,486,314.43** | **96,252,770.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,125,349.43 | 65,451,963.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,840,341.00 | 7,700,202.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,671,833.00 | 6,160,242.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,168,109.00 | 1,539,960.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,680,682.00 | 15,400,403.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,056,645.91** | **27,242,551.47** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,686,109.00 | 5,585,299.47 |
| 210302 | Түлш, халаалт | 10,311,636.91 | 12,802,592.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,058,900.00 | 8,854,660.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,449,531.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | 717,731.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 100,000.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 565,100.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 132,400.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 914,800.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,019,500.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 1,273,919.00 | |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,063,919.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 210,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,000,000.00** | **1,194,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,194,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,369,300.00** | **8,885,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,369,300.00 | 2,081,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 6,804,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,568,700.00** | **40,483,980.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 29,422,060.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,068,700.00 | 11,061,920.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,000,954.66** | **80,329,465.53** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,607,772.00** | **73,909,251.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,153,002.00 | 54,424,050.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,454,770.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 5,104,302.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 14,380,899.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 22,391,028.57 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,391,028.57 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **2,154.09** | **6,420,214.53** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,154.09 | 6,420,214.53 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **42,812,087.20** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **32,043,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **32,043,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | **32,043,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 32,043,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(32,043,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | **10,769,087.20** |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 10,769,087.20 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон /төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **20122 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,264,090,040.84 | 755,697,566.97 | (2,019,787,607.81) | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,264,090,040.84** | **755,697,566.97** | **(2,019,787,607.81)** | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 1,675,979,951.47 | **1,675,979,951.47** |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,264,090,040.84** | **755,697,566.97** | **(343,807,656.34)** | **1,675,979,951.47** |

**2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,063,986,900.00** | **1,044,930,398.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **1,063,986,900.00** | **1,044,930,398.27** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **990,824,700.00** | **976,125,449.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **771,830,700.00** | **770,023,347.80** |
| 210101 | Үндсэн цалин | 583,252,100.00 | 531,816,025.80 |
| 210102 | Нэмэгдэл | 165,513,800.00 | 193,775,984.00 |
| 210104 | Урамшуулал | 23,064,800.00 | 44,431,338.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **99,478,800.00** | **96,252,770.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,645,600.00 | 65,451,963.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,958,300.00 | 7,700,202.00 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 6,366,700.00 | 6,160,242.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,591,600.00 | 1,539,960.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,916,600.00 | 15,400,403.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **33,662,400.00** | **27,242,551.47** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 6,445,900.00 | 5,585,299.47 |
| 210302 | Түлш, халаалт | 16,718,000.00 | 12,802,592.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,498,500.00 | 8,854,660.00 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **1,194,600.00** | **1,194,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,194,600.00 | 1,194,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **9,456,000.00** | **8,885,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,081,200.00 | 2,081,200.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 7,374,800.00 | 6,804,000.00 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **75,202,200.00** | **72,526,980.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,140,000.00 | 61,465,060.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,062,200.00 | 11,061,920.00 |
|  | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **73,162,200.00** | **68,804,949.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **73,162,200.00** | **68,804,949.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 58,781,300.00 | 54,424,050.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 14,380,900.00 | 14,380,899.00 |
|  | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,063,986,900.00** | **1,055,699,485.47** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **991,741,200.00** | **991,741,200.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 991,741,200.00 | 991,741,200.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **61,880,100.00** | **55,459,885.47** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 61,880,100.00 | 55,459,885.47 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **10,365,600.00** | **8,498,400.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,081,200.00 | 2,081,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,284,400.00 | 6,417,200.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 10,769,087.20 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,104,302.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **5,104,302.00** |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,104,302.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **5,104,302.00** |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 5,104,302.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,104,302.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **5,104,302.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,104,302.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2 зөрчил[1] илэрснээс,1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### 3.1 Албан шаардлага

**1. Худалдан авалттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17 дугаар зүйлийн 17.1. “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"  гэсэн заалттай нийцээгүй, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриаар бүртгэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлын нэгтгэл**

| | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Зөвлөмж | | Албан шаардлага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан. | **1** | **-** | | | | | **1** | **-** |
| Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. | **1** | **-** | | | **1** | **-** | | |
| Дүн | **2** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **1** | **-** |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр    Дугаар 97/01 ДОА-2023/118/НА-СТА-ТШ3    Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 11 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

011040417

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын 11 дүгээр сургуулийн захирал В.Алтансувд, нягтлан бодогч Б.Ариунтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.АРИУНАА